



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/34

Мандалговь

“Ган ТЭТ Девелопмент” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2019 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Мэргэжлийн хяналтын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ган ТЭТ Девелопмент” ХХК-тай 24,750,000 (хорин дөрвөн сая долоон зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Мэргэжлийн хяналтын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ган ТЭТ Девелопмент” ХХК-ны захирал (С.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

Гурав.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060150